



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!


№31 /475/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.02.13

Цаг үе, үйл явдал

МОНГОЛЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЦЭРГИЙН ЭМЧ НАР 320 ГАРУЙ ИРГЭНД ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖЭЭ



БНТУ-ын Хатай муж Антакья хотод дэлгэсэн Монгол Улсын Цэргийн хээрийн эмнэлэг 2 дугаар сарын 13 өдрийн байдлаар гамшигт нэрвэгдсэн гэмтлийн болон бусад шалтгаант нийт 320 гаруй иргэнд тусламж үйлчилгээг үзүүлээд байна.

Өчигдөр гэхэд зүрх судасны эмгэгтэй 15, амьсгалын замын эмгэгтэй 23, ясны хугаралтай 14 иргэнд гэмтлийн үеийн тусламж үйлчилгээг үзүүлсэн бол хэвлийн

өвдөлттэй 1 иргэнд үзлэг хийж мухар олгойн цочмог үрэвсэл байсныг оношлон лавлагаа шатлалын эмнэлэгт шилжүүлжээ.

Мөн Турк Улсын Эрүүл мэндийн яамны биет төлөөлөгч болон Тусгай хүчний сектор командлагч нар эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж, хамтран ажиллаж байгаад талархал илэрхийлж шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган ажиллахаа мэдэгджээ.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-8	-24

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,510	3,514
EUR	3,765	3,885
CNY	515	517
RUB	45.20	46
JPY	26.60	26.78
KRW	2.76	2.82

ЗУРХАЙ



2023.02.13 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 23

ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАР БАР ӨДӨР

Үс засуулбал:
Эд эдлэл идээ ундаа олдоно
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.03-18.10
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Хүрэлцэхүй

МОНГОЛ, ЭНЭТХЭГИЙН БХЯ-Д ХООРОНДЫН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ БОЛЛОО



Монгол Улс, БНЭУ-ын Батлан хамгаалах яамд хоорондын 11 дэх зөвлөлдөх уулзалт Шинэ Дели хотноо 2023 оны 2 дугаар сарын 10-ны өдөр амжилттай боллоо.

Зөвлөлдөх уулзалтыг Монголын талаас БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, Энэтхэгийн талаас БХЯ-ны Туслах төрийн нарийн

бичгийн дарга, доктор Ажай Кумар нар тэргүүлж, хоёр талын батлан хамгаалахын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар зөвлөлдлөө. Мөн зөвлөлдөх уулзалтад Монгол Улсаас БНЭУ-д суугаа Элчин сайд Д.Ганболд оролцов.

Энэ удаагийн зөвлөлдөх уулзалтаар өнгөрсөн 2022 онд хийсэн хоёр орны Батлан

хамгаалахын сайд нарын харилцан айлчлалын үеэр тохиролцсон хамтын ажиллагааны асуудлуудыг хэрэгжүүлэх цаг хугацаа, хөтөлбөр тус бүрээр ярилцаж, хамтран зохион байгуулахаар тогтлоо.

Тухайлбал, хоёр орны тусгай хүчний хамтарсан "Нүүдэлчин заан" дадлага, сургуулийг энэ оны 7 дугаар сард Монгол Улсад зохион

байгуулах, энэ үеэр БНЭУ-аас тусламжаар авах эмнэлгийн тусгай тоноглол бүхий автомашин, хүйтний улирлын хувцас зэргийг хүлээн авах, батлан хамгаалахын аж үйлдвэрийн чиглэлээр туршлага судлах төлөөлөгчдийг БНЭУ-д ажиллуулах, энэ онд БНЭУ-ын цэргийн сургуульд сургах цэргийн алба хаагчийн тоо зэргийг харилцан тохиров.



ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ, СУРГАЛТЫГ ЯВУУЛЛАА

Нийслэлийн Засаг зохион байгууллаа. Сургалтаар бие дүүргийн ЗДТГ-ын дарга нарт Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг танилцуулах, орон нутгийн хамгаалалт салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, төрийн батлан хамгаалах үйлчилгээг иргэдэд хүргэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой цэргийн бэлтгэл, сургалтыг БХЯ, ҮБХИС, Зэвсэгт хүчний 015 дугаар ангитай хамтран



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 677,609,790

Эдгэрсэн

Нийт: 650,140,503

Нас барсан

Нийт: 6,782,460

Цахим шууданд

ТӨВ АЙМГИЙН СУМЫН ДАРГА НАР ЦЭРГИЙН СУРГАЛТ БЭЛТГЭЛД ХАМРАГДАВ



Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас “Орон нутгийн хамгаалалтын хууль, Дайчилгааны тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлэх зарим асуудлууд” сэдвийн хүрээнд цэргийн бэлтгэл сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн Засаг дарга бөгөөд Батлан хамгаалах газрын дарга Д.Мөнхбаатар, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Ч.Цогтжаргал, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, Зэвсэгт хүчний 334 дүгээр ангийн удирдлага, 27 сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын

газрын дарга нар оролцсон юм. Батлан хамгаалах бодлого хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэхэд сумдын удирдлагын үүрэг оролцоо, Орон нутгийн хамгаалалтын болон Дайчилгааны хуулийг орон нутагт хэрэгжүүлэх нэгдсэн ойлголт өгөхөд чиглэсэн сургалт болсон бөгөөд бригадын генерал Ч.Цогтжаргал “Бүх нийтийн оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, түүний онцлог” сэдвээр илтгэл тавьж, мэдээлэл өгсөн юм. Сургалтын төгсгөлд орон нутагтаа батлан хамгаалах салбарын

хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд идэвх чармайлттай ажиллаж байгаа Цэргийн штабын тоо бүртгэлийн ахлах офицер, ахмад С.Солонгыг аймгийн Засаг даргын “Хүндэт” тэмдгээр, дайчилгааны офицер, хошууч Б.Бадарчийг Засаг даргын хүндэт “Жуух бичиг”-ээр шагнаж, Эрдэнэ, Батсүмбэр, Өндөрширээт, Баянцогт, Алтанбулаг сумдын ЗДТГ-ын хамт олонд аймгийн Засаг дарга болон Цэргийн штабын батламжийг хадгалууллаа.

Ахмад Д.БОЛОР

УЛАМЖЛАЛТ НААДГАЙГААР ӨРСӨЛДӨВ



Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Хугацаат цэргийн алба хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар Монгол Улсын түүх, уламжлалт соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах зорилготой “Дөрвөн бэрх” тэмцээнийг зохион явуулав. Тэмцээнд 10 багийн 50 орчим хугацаат цэргийн алба хаагч оролцсоноос тэргүүн байрт байлдагч Ц.Цэрэнпунцаг ахлагчтай III мотобуудлагын салаа, дэд байрт байлдагч Б.Галт ахлагчтай танк эсэргүүцэх салаа, гутгаар байрт байлдагч Н.Мягмардорж ахлагчтай тийрэлтэд артиллерийн салаа тус тус амжилттай оролцож шагналт байрт шалгарлаа.

Дэслэгч Б.БАТЗАЯА

"УЧИРТАЙ ГУРВАН ТОЛГОЙ" ДУУРЬ ҮЗЭХ ЭРХ ОЛГОЖЭЭ



Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Албандаа хандах хандлага, үлгэр жишээч байдлаараа бусад нөхдөө манлайлж буй зарим хугацаат цэргийн алба хаагчдаа сайшааж УДБЭТ, Өмнөговь аймгийн хөгжимт жүжгийн театрын уран бүтээлчдийн хамтарсан үндэсний сонгодог бүтээл “Учиртай гурван толгой” дуурь үзэх эрх олгожээ.



Гэрэл зураг-нэг агшин



Алдраа цуурайтуулсан монгол цэрэг
Айл гэрийн ноён нуруу

“ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХЭД ТӨРИЙН ЦЭРГИЙН БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО”...



Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб “Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх замаар эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой “Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэхэд төрийн цэргийн болон төрийн байгууллагуудын оролцоо”

Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллагуудын удирдлагууд оролцоо. Энэ үеэр Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн командлагч, доктор, зөвлөх инженер, бригадын генерал Д.Баасандамба “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба Батлан хамгаалах тогтолцоо”,



сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Зэвсэгт хүчний 330 дугаар анги, Зэвсэгт хүчний 322 дугаар салбар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Гаалийн газар, Татварын хэлтэс,

“Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны өөрчлөлт”, “Орон нутгийн хамгаалалтын тогтолцоо” зэрэг сэдвээр лекц, уншиж холбогдох мэдээ мэдээллийг нийт бие бүрэлдэхүүнд өгсөн юм.

Цахим шууданд

“БАЯРЛАЛАА” АЯН ҮРГЭЛЖИЛСЭЭР ...



Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн залуу офицер, ахлагч нар ангийн нийт бие бүрэлдэхүүний дунд эерэг хандлагыг түгээх, баярлаж талархсан сэтгэлээ илэрхийлж бусдадаа урам өгөх зорилготой “Баярлалаа” аяныг зохион байгуулж байна.

Тийрэлтэд артиллерийн дивизионы хамт олон, Эрүүл мэндийн төвийн хамт олон, Орон сууцны нярав Б.Билэгмаа, тоног төхөөрөмжийн инженер Ө.Сүхбаяр нар баярлаж, талархсан сэтгэгдлээр дүүрэн “Баярлалаа” захидлыг хүлээн авсан юм.

Тухайлбал, өнгөрөгч долоо

Хошууч Ө.НАРАНТУЯА